

ҮАГ

Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын Байнгын хорооны
хүсэлтээр хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

2005 оны
10 дугаар сар

**ДЭЭД БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГАД
ТАВИГДАХ НИЙТЛЭГ ШААРДЛАГЫГ
БҮРЭН ХАНГААГҮЙ БАЙНА**

**МУИС, СУИС-ийн сургалт, эрдэм шинжилгээ,
удирдлага, санхүүгийн үйл ажиллагаа**

Улаанбаатар хот

Агуулга

Ерөнхий зүйл	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3
	Аудитад ашигласан шалгуур	4
	Аудитын стандартын талаархи мэдэгдэл	4
Аудитын дүн	Сургалт зохион байгуулалт	5
	Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр нөлөө	7
	Удирдлагын үйл ажиллагаа	10
	Санхүүгийн үйл ажиллагаа	14
Дүгнэлт		18
Санал	БСШУЯ-ны санал	20
	МУИС-ийн санал	21
	СУИС-ийн санал	26
ҮАГ-ын тайлбар		31
Зөвлөмж		34
Хавсралт	Дээд боловсролын байгууллагад тавигдах үндсэн шаардлагын биелэлт	35

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР:

- ҮАГ – Үндэсний аудитын газар
- БСШУЯ – Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
- МУИС – Монгол Улсын их сургууль
- СУИС – Соёл урлагийн их сургууль
- СУСХ – Соёл урлаг судлалын хүрээлэн
- БМИҮЗ – Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл
- ШУА – Шинжлэх ухааны академи
- ШУТС – Шинжлэх ухаан, технологийн сан
- ТБУСТухай хууль – Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль

Ерөнхий зүйл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын Байнгын хорооны хүсэлт, ҮАГ-ын 2005 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлогдсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд МУИС, СУИС-ийн сургалт, эрдэм шинжилгээ, удирдлага, санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийлээ.

Гүйцэтгэлийн аудит нь дараахь зорилт, дэд зорилтын хүрээнд шалгалт хийж, дүгнэлт гарган, зөвлөмж өгөхөд чиглэгдсэн:

1. Сургалт зохион байгуулалт, үүнд:
 - 1.1 Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр боловсруулалт;
 - 2.1 Онол, дадлагын хичээлийн зохион байгуулалт, хэрэгжилт.
2. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр нөлөө, үүнд:
 - 2.1 Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын хэрэгжилт;
 - 2.2 Хичээлийн хөтөлбөр, агуулгыг боловсруулах, баяжуулахад эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр нөлөө.
3. Удирдлагын үйл ажиллагаа, үүнд:
 - 3.1 Дээд боловсролын байгууллагад тавигдах үндсэн шаардлагын биелэлт;
 - 3.2 Дотоод хяналтын тогтолцоо, түүний үр нөлөө.
4. Санхүүгийн үйл ажиллагаа, үүнд:
 - 4.1 Орлогын эх үүсвэр, бүтэц;
 - 4.2 Санхүүгийн бүртгэл, тайлагнал.

Дээрх сургуулийн сургалт, эрдэм шинжилгээ, санхүүгийн үндсэн баримт, материал, холбогдох мэдээ, тайлангуудыг уншиж танилцан, сургуулийн болон харьяа бүрэлдэхүүн нэгжүүдийн удирдлага, багш, оюутан, БСШУЯ, БМИҮЗ, ШУТС, ШУА-ийн холбогдох ажилтнуудтай уулзаж ярилцах, тайлан мэдээ гаргуулах байдлаар аудитын шинжилгээний болон нарийвчилсан горимын дагуу сорилт, дүн шинжилгээ хийв.

Ерөнхий зүйл

Аудитад ашигласан шалгуур

Дараахь хууль, эрхийн акт, баримт бичгийг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа.

- Боловсролын тухай хууль;
- Дээд боловсролын тухай хууль;
- Засгийн газрын 2003 оны 276 дугаар тогтоол;
- Гэгээрлийн сайдын 1998 оны 61, 255 дугаар тушаал;
- Сургуулийн удирдах зөвлөлийн хурлын тогтоол;
- Сургуулийн дотоод дүрэм, журам;
- Холбогдох бусад хууль, эрхийн актууд.

Аудитын стандартын талаарх мэдээлэл

Энэхүү гүйцэтгэлийн аудитыг хийхэд Төрийн хяналт, шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, Гүйцэтгэлийн шалгалтын журам, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан YAГ-2/2005/06-ГА гүйцэтгэлийн аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болголоо.

Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу аудитын дүгнэлтийг нотлох зүйлс, тэдгээрийг дэмжих болон холбогдох бусад мэдээллийг ажлын баримт материал болгон хавсаргав.

Гүйцэтгэлийн аудитыг YAГ-ын хоёрдугаар хэлтсийн дарга О.Мэндбаяр хянан удирдаж, YAГ-ын Нийгмийн салбарын багийн аудитор, шинжээчид 2005 оны 5 дугаар сарын 17-оос 9 дүгээр сарын 17-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

Аудитын дүн

Сургалт зохион байгуулалт

Ерөнхий зүйл

МУИС анх 1940 онд Засгийн газрын тогтоолоор байгуулагдаж, 1942 оноос 3 салбартай хичээллэж эхэлсэн бол өнөөдөр бүрэлдэхүүндээ 12 сургууль, факультет, 72 тэнхим, 21 эрдэм шинжилгээний хүрээлэн, төв, 1 ахлах сургуультай болж 88 мэргэжлээр бакалаврын, 77 чиглэлээр магистр, 67 чиглэлээр докторын сургалт явуулж байгаа бөгөөд өөрийн харьяанд 3 салбар сургууль, Монгол-Японы төв, Турк-Монголын хамтарсан дунд сургуулийг ажиллуулж байна.

Улсын багшийн дээд сургууль (хуучин нэрээр)-ийн кино-драм, дуулаач, төгөлдөр хуур, ардын хөгжмийн ангийг өргөжүүлж, 1990 онд байгуулагдсан Соёл урлагийн дээд сургуулийг 1992 онд СУИС болгон өөрчилжээ. Өнөөдрийн байдлаар тус сургууль нь 3 факультет, 10 тэнхимтэй, мэргэжлийн боловсрол олгох шаталсан сургалтаар 38 мэргэжлээр бакалаврын, 31 чиглэлээр магистрын, 2 чиглэлээр докторын зэрэг олгох сургалт явуулж байна. СУИС-ийн харьяанд өнөөдөр Дүрслэх урлагийн дээд сургууль, Соёлын дээд сургууль, Хөгжим бүжгийн коллеж, Соёл урлаг судлалын хүрээлэн (СУСХ) үйл ажиллагаа явуулж байна.

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр боловсруулалт

БСШУ-ны Сайдын 2002 оны 390 дүгээр тушаалаар бакалаврын зэргийн боловсролын агуулга, сургалтын орчны наад захын нийтлэг шаардлагуудыг тогтоосон Монгол улсын дээд боловсролын стандартыг 2003 онд багтаан боловсруулах удирдамж гарсан боловч, 2005 оны байдлаар МУИС-д 88 мэргэжлийн стандарт боловсруулагдсаны 1 нь, СУИС-д 30 мэргэжлийн стандарт боловсруулснаас 20 нь батлагджээ.

МУИС, СУИС дээд боловсролын агуулгыг хэрэгжүүлэх үндсэн баримт бичиг болох хичээлийн төлөвлөгөөнд сургалтын зохион байгуулалт, агуулга, хугацаа, судлах хичээлийн цэс, тэдгээрийн багтаамж, дараалал, дадлагын төрөл зэргийг тусгаж байгаа нь Гэгээрлийн сайдын 1998 оны 255 дугаар тушаалаар батлагдсан “Сургалтын баримт бичиг боловсруулахад баримтлах журам”-д нийцэж байна.

ТАСИС хөтөлбөрийн хүрээнд сургалтын хөтөлбөрийн чанарт хөндлөнгийн болон өөрийн үнэлгээ хийлгэх ажлыг МУИС 2001 оноос нэвтрүүлж эхэлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар нийт 20 сургалтын хөтөлбөрт дотооддоо өөрийн үнэлгээ хийсэн ба

нягтлан бодох бүртгэл, менежментийн сургалтын хөтөлбөрт гадны шинжээчдээр хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангаж байна.

СУИС 2004 онд утсан хөгжим болон төгөлдөр хуурын ангийн сургалтын хөтөлбөрт магадлан итгэмжлэл хийлгэх бэлтгэл хангажээ.

Иймд БМИҮЗ дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хийх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Онол, дадлагын хичээлийн зохион байгуулалт, хэрэгжилт

I. Монгол Улсын их сургууль

МУИС онол, дадлагын хичээл зохион байгуулах, хэрэгжүүлэх явцад тавих хяналтыг багш нарын хичээлд суун дүгнэлт гаргах, арга зүйгээр хангах, багш нарыг аттестачлалд хамруулах, оюутнуудаас асуулга авах, сургалтын албадаас багш нарын хичээлийн цагийн ашиглалтын байдалд хяналт тавих зэргээр хэрэгжүүлж иржээ.

2003-2004 оны хичээлийн жилд оюутны дадлагын хичээлийн ерөнхий журмыг шинэчлэн боловсруулж тэнхмийн, хээрийн, үйлдвэрлэлийн зэрэг дадлагын зохион байгуулалт, оролцогч талуудын эрх, үүрэг, оюутны мэдлэгийн үнэлгээний талаар баримтлах бодлогыг тусгажээ.

МУИС-ийн онол, дадлагын хичээлийн зохион байгуулалт нь сургуулиас гаргасан дадлага явуулах журам, сургалт зохион байгуулахтай холбоотой бусад эрх зүйн актын хүрээнд хэрэгжиж байна.

II. Соёл урлагийн их сургууль

СУИС-ийн удирдлагаас баталсан сургалтын дүрмээр онол болон дадлагын хичээлд оролцох бүрэлдэхүүн, танхимын сургалт болон үйлдвэрлэлийн дадлагын хугацааг тодорхойлон өгч, сургалтын үндсэн тэнхим, факультет, багш нарын хөтлөх бичиг, баримтын жагсаалтыг батлан гаргасан нь онол, дадлагын хичээлийг зохион байгуулах, хэрэгжилтийг хангах, ажлын явц, үр дүнг үнэлэх үндсэн баримт болж байна.

СУИС-ийн оюутан, багш нараас аудитын багийн авсан санал асуулгад мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хичээлийн цаг хангалттай бус, компьютерийн танхим, техник хэрэгслийн хүрэлцээ муу, аудио, видео хэрэгсэл, цахилгаан хөгжмийн лаборатори, электрон мэдээллийн номын фонд дутагдалтай байдаг талаар дурджээ.

Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр нөлөө

Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын хэрэгжилт

Дээд боловсролын тухай хуульд “их сургууль нь шинжлэх ухааны хэд хэдэн чиглэлээр суурь ба хавсарга судалгаа явуулдаг ... эрдэм шинжилгээ-сургалтын байгууллага байна” гэж заажээ.

Эрдэм шинжилгээний ажил, түүний сонгон шалгаруулалт чөлөөт өрсөлдөөнд үндэслэх ёстой боловч ШУА-ийн харъяа эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн үйл ажиллагаа ШУТС-ийн санхүүжилтээс шууд хамааралтай, тэдгээрийн дунд өрсөлдөөний орчин бүрдээгүйгээс төслийн шалгаруулалт, санхүүжилтийг хуваарилах байдлаар явуулж ирсэн байна.

ШУТС нь шинжлэх ухаан, технологийн төслийг санхүүжүүлэх, төслийн үр дүнг үнэлэх байгууллага гэж тодорхойлсон боловч аудитын явцад уншиж танилцсан материал, эрдэмтэн, багш, холбогдох хүмүүстэй хийсэн ярилцлагаас үзэхэд тус сан нь зөвхөн мөнгө дамжуулах төдий үүрэгтэй байгууллага болсон гэж дүгнэхээр байна.

2004 оны байдлаар улсын хэмжээнд шинжлэх ухаан, технологийн төсөл 169, суурь судалгааны сэдэвт ажил 158, судалгааны ажил 11 хэрэгжиж байгаа бөгөөд эдгээрт ШУТС-аас 4,7 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгджээ. Үүнээс МУИС шинжлэх ухаан технологийн төсөл 8, суурь судалгааны сэдэвт ажил 33-ыг гүйцэтгэж, нийт 224.0 сая төгрөгийн санхүүжилт авсан бол СУИС судалгаа, шинжилгээний 2 төсөлд 23,4 сая төгрөгийн санхүүжилт авч хэрэгжүүлжээ.

I. Монгол Улсын их сургууль

2004 онд МУИС-аас 21 суурь судалгааны сэдэв дэвшүүлэн салбарын бага чуулганаар хэлэлцүүлснээс 4 нь 15.5 сая төгрөгийн санхүүжилт авч, бусад нь санхүүжилтгүйн улмаас хэрэгжих боломжгүй хүлээгдэж байна.

Аудитын дүн

Цөмийн судалгааны төв, Физик, электроникийн сургууль хамтран 2002 оноос уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийн технологийн шинэчлэлтэй холбоотой “Баяжуулалтад орох хүдрийн эрдсийн фазыг тодорхойлох түргэвчилсэн арга” сэдэвт эрдэм шинжилгээний ажлын 8000 ам долларын гэрээ байгуулан ажиллаж, үр дүнг 2004 онд хүлээлгэн өгснийг эс тооцвол МУИС аж ахуйн нэгж, байгууллагатай эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чиглэлээр хамтарч ажиллах явдал хангалтгүй байна.

МУИС, БНСУ-ын Ахисан түвшний судалгааг дэмжих сангийн хооронд байгуулсан хамтын ажиллагааны гэрээний дагуу МУИС-ийн эрдэм шинжилгээний ажлыг санхүүжүүлэх, дэмжлэг үзүүлэх зорилго бүхий Азийн судалгааны төв 2003-2004 онд 57.9 сая төгрөгийн санхүүжилттэй 15 төсөл хэрэгжүүлжээ.

Эрдэм шинжилгээний онолын их семинарыг 2004 онд 77 удаа явуулж 91 илтгэл хэлэлцжээ.

№	МУИС-ийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын хэлбэрүүд	2003		2004	
		Тоо	Сая төг	Тоо	Сая төг
1.	ШУТС-ийн санхүүжилттэй	29	135,8	33	160,2
2.	Улсын захиалгаар хийгдэж буй	6	59,1	8	63,8
3.	Дотоод төсөл, гэрээт ажил	4	10,5	3	8,5
4.	Азийн судалгааны төвтэй хамтарсан	15	58,0	13	58,0
5.	Гадаадын байгууллагатай хамтарсан	61	-----	61	-----
Бүгд		115	263,4	118	291,3

II. Соёл, урлагийн их сургууль

СУСХ 8 эрдэм шинжилгээний ажилтан, нийт 11 хүний орон тоо бүхий соёл урлагийн суурь болон хавсарга судалгаа явуулах чиг үүрэг бүхий байгууллага бөгөөд 1993 онд ШУА-аас СУИС-ийн харъяанд шилжин иржээ.

2001-2004 онд “Монголын театрын урлаг”, “Монголын хөгжмийн урлаг”, “Монголын дүрслэх урлаг” болон “Монголын соёл судлалын зангилаа асуудал” хэмээх суурь судалгаа хэрэгжүүлсэн байна.

СУИС эрдэм шинжилгээний хурлыг 8 удаа зохион байгуулж, 37 илтгэл хэлэлцүүлж, үр дүнг эрдэм шинжилгээний бичиг болгон хэвлүүлжээ.

№	СУИС-ийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын хэлбэрүүд	2003 он		2004 он	
		Тоо	Сая төг.	Тоо	Сая төг.
1.	ШУТС-ийн санхүүжилттэй	2	17,4	2	23,4

Хичээлийн хөтөлбөр, агуулгыг боловсруулах, баяжуулахад эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр нөлөө

I. Монгол Улсын их сургууль

МУИС дүрмэндээ шинжлэх ухааны олон салбараар судалгаа хийж, үр дүнг нь сургалт, үйлдвэрлэлд нэвтрүүлэх чиг үүрэг бүхий байгууллага хэмээн өөрийгөө тодорхойлсон тул сургууль, эрдэм шинжилгээний төв, хүрээлэнгээс хэрэгжүүлсэн болон багш нарын хувиараа хийж байгаа эрдэм шинжилгээ, судалгааны ажил хичээлийн хөтөлбөрөөр дамжин, сургалтын агуулгыг шинэчлэх, боловсронгуй болгоход хэрхэн нөлөөлж байгааг хянаж, үнэлж байх шаардлагатай байна.

МУИС орчин үеийн боловсролын хөгжлийн чиг хандлагын судалгаа, боловсролын стандарт болон каррикулумыг шинэчлэн хөгжүүлэх асуудлаар Мэргэжлийн дидактикийн сургалт, судалгааны төв байгуулан ажиллуулж байна. Ингэснээр математик, физик, хими, биологи, газар зүй зэрэг байгалийн ухааны салбарын боловсрол судлалд гарч буй парадигмын өөрчлөлтийг судалж дээрх мэргэжлийн хичээлийн хөтөлбөрт зарим нэг шинэчлэл хийж эхэлжээ.

II. Соёл, урлагийн их сургууль

СУИС-ийн Удирдах зөвлөлөөс баталсан “СУИС-ийн мастер төлөвлөгөө”-нд эрдэм шинжилгээний ажлыг магистр, докторын сургалттай нягт холбох зорилтыг дэвшүүлжээ.

2003-2004 оны хичээлийн жилд Монголын нээлттэй нийгмийн хүрээлэнгийн санхүүжилтээр соёл, урлагийн менежментийн магистрын зэргийн сургалтын агуулгыг шинэчлэн тогтоох төслийн хүрээнд сургалтын төлөвлөгөө боловсруулжээ.

СУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтнууд СУИС-ийн бүх шатны сургалтад хичээл заах, сургалтын хөтөлбөр боловсруулах, магистр, докторын судалгааны ажил удирдах, шүүмж бичихэд оролцож, СУИС-ийн багш нар гэрээгээр хүрээлэнгийн судалгааны ажилд хамтран ажиллаж байна.

Тус хүрээлэн СУИС-ийн захирлын удирдлага дор үйл ажиллагаа явуулдаг боловч санхүүжилтийн хувьд ШУТС-аас олгож байгаа төслийн санхүүжилтээс шууд хамааралтай явж иржээ.

Аудитын дүн

Удирдлагын Дээд боловсролын байгууллагад тавигдах үндсэн үйл ажиллагаа шаардлагын биелэлт

Дээд боловсролын сургалтын байгууллага магадлан итгэмжлэл хийлгэхэд Гэгээрлийн сайдын (хуучин нэрээр) 1998 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Дээд боловсролын байгууллагад тавигдах нийтлэг шаардлага”-ын биелэлт болон элсэлтийн талаар тогтоосон дүрэм журам, хэм хэмжээг баримтлах шаардлага нэн түрүүнд тавигддаг байна.

Гэтэл эдгээр сургуулиуд Монгол Улсын Гэгээрлийн сайдын 1999 оны 16 дугаар тушаалаар батлагдсан “Мэргэжлийн сургуулийн элсэлтийн үлгэрчилсэн журам”-аас гадуур, батлагдсан хяналтын тооноос илүү оюутан элсүүлсэн, “Дээд боловсролын байгууллагад тавигдах нийтлэг шаардлага” дараахь байдлаар хангагдаагүй байхад 2004 оны 7 дугаар сард 2 дахь шатны магадлан итгэмжлэлийг 10 жилийн хугацаатай авчээ.

I. Монгол Улсын их сургууль

МУИС өөрийн эзэмшлийн бүгд 8296 суудал бүхий хичээлийн 6 байр, 1380 ор бүхий оюутны 5 байртай үйл ажиллагаа явуулж, байрны нийт талбайн 72.3 хувийг сургалтын зориулалтаар ашиглаж байна.

Тус сургууль “Дээд боловсролын байгууллагад тавигдах нийтлэг шаардлага”-ын **25** үзүүлэлтээс **16**-г хангаж, суралцагч оюутны тоотой холбогдох **9** үзүүлэлтийг хангаагүй байна. Тухайлбал:

- Нэг оюутанд ногдох талбай болон лаборатори, кабинетын нэг суудалд ногдох талбай стандартын шаардлагаас 20%- 30% доогуур байна.
- Ээлж ашиглалтын коэффициент 30%-иар бага байгаа нь анги танхим дахь суудлын тоог хэтрүүлсэнтэй холбоотой байна.
- Оюутны байрны нэг оюутанд ногдох талбайн стандарт хэмжээг хэтрүүлж 1 өрөөнд нормоос олон оюутан амьдрах явдал түгээмэл байна.
- Номын сангийн суудал, фондын баяжилт болон мэргэжил тус бүрээр захиалагдах ёстой дотоод, гадаадын тогтмол хэвлэл, сэтгүүлийн нэр төрөл, тоо зэрэг нь шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна.
- Компьютерын дадлагын болон мэргэшүүлэх, мэргэжлийн суурь хичээлд суралцах оюутны тоог шаардлагын түвшин (15-аас ихгүй байх)-гээс хэтрүүлж, 18-27 оюутантайгаар зохион байгуулж байна.

Аудитын дүн

- Анги дүүргэлтийн хувьд 30-50 оюутантай хичээллүүлж, тогтоосон нормативыг 66 хүртэл хувиар хэтрүүлжээ.

Тус сургуулийн хичээлийн зориулалттай байр талбай бодитой нэмэгдээгүй байхад БСШУЯ-наас жил бүр элсэлтийн тоог өсгөж ирсэн, мэргэжлийн сургуульд оюутан элсүүлэх журам зөрчиж, БСШУЯ-наас тогтоосон хяналтын тооноос хэтрүүлэн их хэмжээний төлбөрийг төрийн бус байгууллагын дансанд төлүүлэх нөхцөлөөр олон тооны оюутан нэмж элсүүлсэн, шилжүүлэн авсан гэх мэтчилэн суралцагчдын тоог нэмэгдүүлж ирсэн нь хичээлийн анги, танхим, багшлах боловсон хүчний дутагдалтай байдлыг бий болгожээ.

МУИС сургалтын зорилгоор ашиглаж байгаа өөрийн байр, талбайн хүчин чадлын хэмжээнд 6350 оюутантай хичээллэх ёстой байна. Хичээлийн 6 дугаар байранд гадны сургуулиудад сургалтын зориулалтаар ашиглуулж байгаа 993.03 кв.м талбайг сургууль өөрөө ашигласан бол 6950 оюутан суралцах нөөц бололцоо байжээ.

Гэтэл 2003-2004, 2004-2005 оны хичээлийн жилд тус сургуульд элсэгчдийн хяналтын тоо жил тутам 200-255-аар нэмэгдсэн төдийгүй тус сургууль өөрөө элсэлтийн шалгалтын журам зөрчиж 816, шилжүүлгээр 203 оюутан нэмж суралцуулснаас оюутны тоо 9086 (эчнээ, оройн ангийн оюутнуудыг оролцуулалгүйгээр) хүрсэн нь хүчин чадалд суурилсан стандартын шаардлагаас 43%-иар буюу 2736-аар их байна.

Багшлах боловсон хүчний тухайд авч үзвэл тус сургуульд 2004-2005 оны хичээлийн жилд 180 гаруй цагийн багш 47,0 мянга гаруй цагийн хичээл заасан бөгөөд 2003-2004 оны хичээлийн жилд шинээр 46 багшийг ажилд авсан бол 2004-2005 оны хичээлийн жилийн төгсгөлд 64 хичээлийн сэдвээр 70 гаруй багшийг нэмж авахаар зарласан байна.

ТБУСТухай хуулиар улсын төсвийн байгууллага, албан тушаалтан зээл авахыг хориглосон байдаг.

Гэтэл тус сургууль “МУИС хөгжлийн сан” ТББ-ын хөрөнгөөр худалдан авсан барилгын хуучин суурь болон баригдаж буй хичээлийн байрны барилгыг барьцаалан Голомт банкнаас 563,2 сая төгрөгийн зээлийг 2005 оны 7 дугаар сараас эхлэн 1 жилийн дотор хүүгийн хамт бүрэн төлж барагдуулах үндсэн нөхцөлөөр, шинэ хичээлийн байрны барилгын ажлыг санхүүжүүлэх зорилгоор авчээ. Тендер шалгаруулалтын үндсэн дээр “Нийслэл өргөө” ХК барилгын ажлын гүйцэтгэгчээр шалгарч, 2005 оны 7 сард ашиглалтад өгөхөөр гэрээ хийж барилгын

ажлыг гүйцэтгэсэн. Гэтэл зээлийн эргэн төлөх хугацаа эхэлчихсэн байхад хичээлийн байрны барилга ашиглалтад ороход ойролцоогоор 20%-ийн гүйцэтгэл дутуу байна.

Банкнаас авсан үндсэн зээл болох 563,0 сая төгрөг болон 2005 оны 9 дүгээр сараас хойшхи хүүгийн тооцоолсон төлбөр 40,0 орчим сая төгрөг нийлээд тухайн сургуулийн жилийн нийт орлогын 15% болж байна. Энэхүү зээл, зээлийн хүүгийн төлбөр МУИС-ийн 2005-2006 оны хичээлийн жилийн санхүүгийн хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

II. Соёл урлагийн их сургууль

Өнөөгийн байдлаар тус сургууль өөрийн эзэмшлийн 916 суудал бүхий хичээлийн нэг байр, бусдын эзэмшлийн 170 ор бүхий оюутны байртай үйл ажиллагаа явуулж байна.

Дээд боловсролын байгууллагад тавигдах үндсэн шаардлагын **25** үзүүлэлтээс **14** буюу 56%-ийг хангаж, хичээлийн болон оюутны дотуур байр, талбайтай холбоотой шаардлагыг хангаагүй байна. Тухайлбал:

- Нэг оюутанд ногдох талбай, лаборатори, кабинетийн нэг суудалд ногдох талбай стандартын шаардлагаас 20%-45%-иар доогуур байна.
- 1 багшид оногдох талбайн хэмжээ шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна.
- Оюутны дотуур байрны талаархи үзүүлэлтүүдийг хангаж ажиллахгүй, оюутны байрны 1 оюутанд оногдох талбайн хэмжээ шаардлагын түвшинд хүрэхгүй байна. 170 ор бүхий оюутны дотуур байрны барилга нь тус сургуулийн өөрийн эзэмшлийнх бус бөгөөд Боловсролын яамны сайдын 1991 оны 358 дугаар тушаалаар тухайн үеийн Гадаад хэлний дээд сургуулийн оюутны байрыг түр эзэмшүүлэх шийдвэрийн дагуу одоог хүртэл тус байрны 1-3 дугаар давхрыг эзэмшиж байна.
- Сургуулийн барилга нь хичээлийн байрны зориулалтаар бус, 1957 онд Барилгын яамны албан конторын зориулалтаар баригдсан байшин учраас олон жижиг өрөөнүүдтэй байдаг нь ганцаарчилсан буюу дэд бүлгийн хичээлийн хувьд боломжтой ч, 40-өөс дээш оюутантай лекцийн хичээл явуулах танхим байхгүй, хэт олон оюутан агааржуулалтын нөхцөл, эрүүл ахуйн шаардлага хангахгүй анги танхимд хичээллэж байна. Хичээлийн байр зориулалтын биш, анги танхим хүрэлцэхгүй байгаа талаар БСШУЯ, Төрийн өмчийн хороо, СЭЗЯ, Засгийн газарт удаа дараа хүсэлт тавьсны

дүнд Сүхбаатар дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт байгаа, оройн ээлжийн сургуулийн зориулалтаар барьж байгаад орхисон 0.42 га талбай бүхий дуусаагүй барилгыг тус сургуульд өгөхөөр шийдвэр гарсан байна.

- Мөн номын сангийн фондын баяжилт шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна. Хөгжмийн боловсрол олгох сурах бичиг, ном, гарын авлагын хүрэлцээ, хангамжийг сайжруулахад анхаарах шаардлагатай байна.

Тус сургуулийн хичээлийн болон оюутны байрны хүчин чадал бодитой нэмэгдээгүй байхад БСШУЯ-аас жил бүр оюутны элсэлтийн хяналтын тоог дунджаар 20-80-аар нэмэгдүүлж иржээ.

Дотоод хяналтын тогтолцоо, түүний үр нөлөө

I. Монгол Улсын их сургууль

МУИС-ийн удирдлагын тогтолцоо нь Удирдах зөвлөл, Эрдмийн зөвлөл, Захирал болон түүний дэргэдэх захиргааны зөвлөл юм.

Тус сургууль ажилтантай хөдөлмөрийн гэрээ хийх, ажлын байрны тодорхойлолтыг боловсруулж, ажилтан бүртэй ажил үүргийн хуваарийг баталж, хариуцлага тооцож ажиллах талаар хангалтгүй ажиллаж байна. Тухайлбал, 2005 оны 4 дүгээр сард шинэчлэн байгуулагдсан захиргааны албаны ажилтнууд, Газар зүй, геологийн факультет, Математик, компьютерийн сургуульд багшаар авч ажиллуулсан нийт 26 багш албан тушаалтнуудын хөдөлмөрийн гэрээ, түүний биелэлт, ажлын байрны тодорхойлолтыг түүвэрлэн үзэхэд Хөдөлмөрийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1.2.3 дугаар зүйлийг зөрчиж, хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй, ажлын байрны тодорхойлолтыг боловсруулаагүй байна.

Санхүүгийн дотоод хяналтын мэргэжилтнийг шинээр ажиллуулж, төв болон салбар сургууль, факультетуудад баримтын шалгалт хийлгэснээр санхүүгийн баримт бүрдүүлэлт сайжирч байна.

2003-2004 оны хичээлийн жилд багш нарыг аттестатчилах ажлыг зохион байгуулж, аттестатчиллын явцад оюутнаас авдаг асуулгын агуулгыг шинэчилсэн байна.

Оюутнуудаас авсан санал асуулгаар хичээлийн агуулга, багш нарын заах ур чадвар, ном, сурах бичиг, хичээлийн техник

Аудитын дүн

хэрэгслийн хангамж, хүрэлцээний талаар хангалтгүй үнэлгээ өгөгджээ.

II. Соёл урлагийн их сургууль

СУИС-ийн захирлын 2003 оны 238 дугаар тушаалаар, сургуулийн сургалтын үндсэн нэгж тэнхим, факультет, профессор багш нарын хөтлөх бичиг баримт, мөрдөх хууль эрхийн актын жагсаалтыг баталжээ. Аудитын явцад Хөгжмийн урлагийн факультет, Дуулах урлагийн тэнхим, Соёл урлагийн удирдлагын факультетийн декан, эрхлэгч нарын хөтлөх ёстой 16 нэр төрлийн бичиг баримттай танилцахад хөтлөлт хэвийн, үйл ажиллагаа нь тогтмолжсон байна.

Санхүүгийн үйл ажиллагаа

Орлогын эх үүсвэр, бүтэц

Төрийн өмчийн сургалтын байгууллагын санхүүжилтийн талаар Боловсролын тухай хуулийн 40.2-т “Их сургууль, дээд сургууль, коллежийн тогтмол зардлыг улсын төвлөрсөн төсвөөс ... санхүүжүүлнэ” гэж заажээ.

Гэвч төрийн өмчийн их, дээд сургуулиудад тогтмол зардлын санхүүжилтийг улсын төсвөөс олгохыг 2003 оноос бүрэн зогсоосон нь дээрх хуулийн заалттай нийцэхгүй байна. Сургуулиуд энэ зардлыг сургалтын төлбөрт шингээн тооцож авч байгаа тул сургуулиудын тухайд санхүүжилт дутагдаагүй гараагүй байна.

Дээд боловсролын тухай хуулийн 18.1-т “Төрийн өмчийн их сургууль, дээд сургууль, коллежийн санхүүжилт дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

- 18.1.1. улсын төсвийн хөрөнгө;
- 18.1.2. эрдэм шинжилгээ, судалгааны ажлын төслийн санхүүжилт;
- 18.1.3. сургалтын төлбөр;
- 18.1.4. аж ахуйн үйл ажиллагааны орлого;
- 18.1.5. аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив;
- 18.1.6. зээл, тусламж;
- 18.1.7. бусад эх үүсвэр.”

гэж заажээ.

Ийнхүү төрийн өмчийн сургуулиудад үйл ажиллагааны санхүүжилтийн нилээд олон эх үүсвэр, арга, хэрэгсэл байгаа боловч оюутны сургалтын болон дотуур байрны төлбөр, аж

Аудитын дүн

ахуйн дотоод орлогоос өөр орлогын эх үүсвэрийг тэр бүр ашиглаагүй байна.

БСШУЯ сургалтын төлбөрийг хянаж байгаагаас их, дээд сургуулиуд орлого нэмэгдүүлэхийн тулд байр талбайн хүчин чадал, баталсан тоо хэмжээнээс хэтрүүлэн оюутан нэмж элсүүлэх хандлагатай болжээ.

I. Монгол Улсын их сургууль

Тус сургуулийн сүүлийн 3 жилийн санхүүгийн тайланд илэрхийлэгдсэн орлого, санхүүжилтийн гүйцэтгэлийг авч үзвэл:

Орлогын нэр төрөл	2002 он	мянган төгрөгөөр	
		2003 он	2004 он
Улсын төсвийн санхүүжилт	328920.9		
Сургалтын төлбөрийн орлого	3000417.6	3131338.3	3698693.9
Эрдэм шинжилгээ, судалгааны төсөлт ажлын санхүүжилт	-	-	-
Хандив тусламжийн орлого		42.8	35618.5
Шилжих төлбөрийн орлого	33102.6	56514.6	76398.6
Оюутны байрны орлого	37484.5	149239.3	206111.2
Бусад орлого	34830.7	80061.2	35426.3
Туслах үйл ажиллагааны орлого	191037.2	188802	276547.2
Нийт орлого	3625793.5	3605998.2	4338831.9
Хандив тусламжийн орлого	157909,9	182350,4	235795,0
Оюутны тоо	9851	10017	11298

Сүүлийн 3 жилд оюутны тоо жил тутам 1200 –аар өсч ирсэн нь тус сургуулийн сургалтын төлбөрийн болон сургалтын бус үйл ажиллагааны орлого жилээс жилд нэмэгдэхэд нөлөөлжээ. Тухайлбал, оюутны сургалтын төлбөрийн орлого 130 – 567 сая төгрөгөөр, оюутны байрны орлого 56,8 - 111,7 сая төгрөгөөр, оюутны шилжилтийн төлбөрийн орлого 19,9-23,4 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

II. Соёл урлагийн их сургууль

Тус сургуулийн сүүлийн 3 жилийн санхүүгийн тайланд илэрхийлэгдсэн орлого, санхүүжилтийн гүйцэтгэлийг авч үзвэл:

Орлогын нэр төрөл	2002 он	мянган төгрөгөөр	
		2003 он	2004 он
Улсын төсвийн санхүүжилт	57684,1		
Сургалтын төлбөрийн орлого	285373,9	337820,8	345579,4
Эрдэм шинжилгээ, судалгааны төсөлт ажлын санхүүжилт	-	-	-
Бусад орлого			5000,0
Туслах үйл ажиллагааны орлого	56364,9	79559,3	37281,3
Нийт орлого	399422,9	417380,1	387860,7

Аудитын дүн

СУИС-ийн үйл ажиллагааны орлогын эх үүсвэрийг үндсэнд нь улсын төсвийн санхүүжилт (2003 оноос зогссон), үндсэн үйл ажиллагааны орлого буюу сургалтын төлбөр, туслах үйл ажиллагааны орлого гэж ангилж байна.

СУИС нь 2004 оны санхүүгийн жилд нийт 394,9 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлснээс үндсэн үйл ажиллагааны орлогоос нийт 351,2 сая төгрөг буюу 88,9 хувийг, 43,7 сая төгрөг буюу 11,1 хувийг үндсэн бус үйл ажиллагааны орлогоос бүрдүүлжээ.

Тухайн сургуулийн сургалтын онцлог, мэргэшүүлэх хичээлийн хөтөлбөрийн зохион байгуулалттай холбоотойгоор 1 багш харьцангуй цөөн оюутантай хичээллэх, нөгөө талаас 2 ба түүнээс дээш тооны багштай мэргэшүүлэх чиглэлийн ганцаарчилсан сургалт нилээд явагддаг тул үзүүлж буй сургалт, үйлчилгээний зардлыг сургалтын төлбөрөөр нөхөж чадахгүйд хүрдэг байна.

Санхүүгийн бүртгэл, тайлагнал

СЭЗ-ийн сайдын 2002 оны 253 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлого”-ын дагуу МУИС болон СУИС санхүүгийн нэгдсэн тайланг бэлтгэн гаргаж, УАГ-ын гэрээт аудитын компаниудаар жилийн санхүүгийн тайландаа аудит хийлгэж, дүгнэлт гаргуулж иржээ. Санхүүгийн тайлангийн аудитаар сургуулиудад нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой материаллаг зөрчил илрээгүй байна.

Харин энэ удаагийн аудитын явцад удирдлагын болон дотоод хяналтын систем, санхүүгийн тайлагналтай холбоотой зарим зөрчил дутагдал илэрсэн болно.

I. Монгол Улсын их сургууль

МУИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудыг санхүүгийн удирдлагын нэгж болгон зохион байгуулж, үйл ажиллагааны үр дүнг тусгайлан тооцдог болсон нь харьяа салбар сургууль, тэнхмийн санхүүгийн бие даасан байдлыг бэхжүүлэх чухал алхам болжээ.

Гэхдээ нягтлан бодох бүртгэл хөтлөлтөөр дамжин боловсруулагдаж байгаа мэдээллийн үнэн зөв байдалд тавигдах ажил үүргийн зохион байгуулалттай холбоотой хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

МУИС-ийн үйл ажиллагааны тайлангаас үзэхэд зөвхөн 2004 онд тус сургууль дээр болон харьяа эрдэм шинжилгээний нэгжүүд дээр ШУТС-аас санхүүжсэн 41, гадаадын байгууллагатай хамтарсан 61, Азийн сангийн санхүүжилттэй 13, өөрийн санхүүжилттэй 3, бүгд 115 эрдэм шинжилгээний төсөл, судалгааны ажил хэрэгжүүлж, эдгээрт 291 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон мэдээлэл байх боловч МУИС-ийн салбар нэгжүүдийн болон нэгдсэн санхүүгийн тайланд эдгээр эрдэм шинжилгээ, судалгааны төсөлт ажлын санхүүгийн орлого, зардал, үр дүнг огт тусгаагүй явж ирсэн байна.

II. Соёл урлагийн их сургууль

СУИС нь оюутны сургалтын төлбөрийг харилцах дансанд төвлөрүүлж, кассаар зөвхөн зарлагын гүйлгээ хийж, орлого төвлөрүүлэх болон төсвийн хөрөнгийн зарцуулалтад нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг зохион байгуулсан байна.

СУИС их сургууль болохын хувьд эрдэм шинжилгээ, судалгааны ажил нь сургалтын үйл ажиллагаатай эн зэрэгцэхүйц ач холбогдол бүхий голлох үйл ажиллагааны төрөл байх ёстой. Гэтэл СУИС үйл ажиллагааны тайландаа СУСХ-ээс хэрэгжүүлсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүн, гүйцэтгэсэн үйл ажиллагааг нэгтгэн тайлагнадаг мөртлөө санхүүгийн үйл ажиллагаа, үр дүнг нэгтгэж тайлагналгүй явж иржээ. Иймд үйл ажиллагааны чиглэл, зорилго болон удирдлагын нэгдмэл байдлын үүднээс тус хүрээлэнгийн санхүүгийн үйл ажиллагааг СУИС-ийн санхүүгийн үйл ажиллагаатай нэгтгэн, тайлагнах шаардлагатай байна.

Дүгнэлт

Дээд боловсролын стандартыг боловсруулах, батлуулах ажил удаашралтай байна.

Хичээлийн хөтөлбөрийг боловсруулах, баяжуулахад тавигдах шаардлага бүрэн хангагдаагүй, сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэх үйл ажиллагаа эхлэл төдий байна.

ШУТС эрдэм шинжилгээ, судалгааны төсөлт ажлын сонгон шалгаруулалтыг чөлөөт өрсөлдөөний хэлбэрээр явуулж чадахгүй байна.

Их сургуулиуд аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран шинжлэх ухаан, технологийн шинжилгээ, судалгааны ажил хийх талаар хангалтгүй ажиллаж байна.

Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг сургалтад нэвтрүүлэх явдал хангалтгүй, энэ талаар удирдлагаас тавих хяналт сул байна.

МУИС болон СУИС дээд боловсролын байгууллагад тавигдах нийтлэг шаардлагыг бүрэн хангаж ажиллаагүй, элсэлтийн талаар тогтоосон дүрэм, журам, хэм хэмжээг бүрэн мөрдөөгүй байна.

БМИҮЗ дээд боловсролын байгууллагад тавигдах нийтлэг шаардлагыг бүрэн хангаагүй сургалтын байгууллагыг магадлан итгэмжилж байжээ.

БСШУЯ их, дээд сургуулиудад элсэлтийн хяналтын тоог баталж өгөхдөө Дээд боловсролын тухай хуулийн дөрөвдүгээр бүлгийн 7-2-т заасны дагуу мэргэжилтний хэрэгцээ, захиалга, сургуулийн хүчин чадлыг тэр бүр харгалзаагүй байна.

Их сургуулиудын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүн болон түүнээс олох орлого хангалтгүй байна.

Их сургуулиуд харьяа эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн, төвийн гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, судалгааны төсөлт ажлын гүйцэтгэл, үр дүнг үйл ажиллагааныхаа тайланд тусгаж байгаа боловч, түүний санхүүгийн мэдээлэл, үр дүнг санхүүгийн нэгдсэн тайландаа тусгалгүй орхигдуулж иржээ.

Санал

БСШУЯ-ны
санал



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

Улаанбаатар, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Баянхайрруу 44, Засагын газрын 8 байр,
Утас 26-24-80, Факс 33-31-66
E-mail: maa@maa.gov.mn
Web: www.maa.gov.mn

2005.09.30 № 30/НННТ

Танай _____-ийн № _____-т

Танай 263 тоотын хариу

Танай 2005 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 263 тоот албан бичгээр ирүүлсэн Монгол улсын их сургууль, Соёл урлагийн их сургуулийн 2003/2004 оны болон 2004/2005 оны хичээлийн жилийн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангийн төсөлд МУИС, СУИС-ийн үйл ажиллагаа болон БСШУЯ-ны зарим үйл ажиллагаатай холбоотой зөрчил дутагдлыг үндсэнд нь зөв зүйтэй гаргаж тавьсан байна. Дараах саналтай байна.

Үүнд:

Тайлбар 1.1 - 1.2-
ыг үзнэ үү.

1.Тус сургуулиуд дээр элсэлтийн хяналтын тоог жил бүр 100-255 хүнээр хэтрүүлсэн болон журам зөрчиж 816 хүн элсүүлсэн гэсэн тоог дахин нягталж шалтгааныг нь тодруулах.

2.Төрийн өмчийн ашгийн бус байгууллага болох МУИС нь өргөтгөлийн барилга барихдаа арилжааны банкнаас зээл авсан нь холбогдох хууль тогтоомжтой нийцсэн эсэх, Сангийн яам, Төрийн өмчийн хороо, Улсын мэргэжлийн хяналтын газар зэрэг байгууллагууд ямар мэдээлэлтэй байгаа тухай лавлагаа гаргуулж, аудитын тайланд энэ талаар дүгнэлт гаргуулж, тусгуулах саналтай байна.



МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.БАЯР

D: /My Documents/ doc A-4

0002353

МУИС-ийн санал



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТИЙН ГАЗРЫН II ХЭЛТСИЙН
ДАРГА О.МЭНДБАЯР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

210648 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Их сургуулийн гудамж 1, Утас/Факс: 32-06-88

2005.10.7 № 11577
танай 2005.04.26-ны № 283-т

Тайлбар хүргүүлэх тухай

УИХ-ын Нийгмийн Бодлогын Байнгын Хоррооны хүсэлтийн дагуу МУИС-д хийсэн гүйцэтгэлийн аудитийн тайлангийн төсөлтэй танилцаад холбогдох тайлбарыг хүргүүлэв.

Ул суурьтай нягтлан үзэж холбогдох залруулгыг хийнэ гэдэгт итгэж байна.



Д-р, Проф. Ц.ГАНЦОГ

МУИС-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд өгөх тайлбар

Тайлбар 2.1 -ийг үзнэ үү.

Хуудас 6. Эхний өгүүлбэр:

Хичээлийн хөтөлбөр боловсруулахад тавигдах шаардлагын талаар:
- Хэрэв "сургалтын төлөвлөгөө" гэж ойлгох бол МУИС-ийн Бакалаврын сургалтын журмын *Сургалтын төлөвлөгөө* (эмхэтгэлийн 79-р хуудас) гэсэн хэсэгт зааснаар зохицуулагдана. Энэ хэсэгт ерөнхий эрдмийн хичээл, мэргэжлийн заавал судлах хичээл болон мэргэшүүлэх хичээлүүдийн хөтөлбөрийг хэн хариуцаж, боловсруулахыг тодорхой заасан байна. Хичээлийн хөтөлбөр нь тухайн хүчин төгөлдөр байгаа сургалтын төлөвлөгөөний дагуу боловсруулагдан багш, тэнхим, сургалтын алба зэрэгт байхаас гадна жил бүр оюутанд хүрсэн байна.
- Хичээлийн хөтөлбөр боловсруулах ерөнхий заавар нь МУИС-ийн Бакалаврын сургалтын журам анх 1998 онд боловсруулахад гарч хичээлийн индекс, залгамж холбоо, хичээл судлахад урьдчилан бүрдүүлэх нөхцөл, хичээлийн товч агуулга, оюутны мэдлэгийг үнэлэх арга, ашиглах материал зэргийн хамт тогтсон нэг загвараар боловсруулагдаж ирсэн.

Тайлбар 2.2 -ыг үзнэ үү.

Хуудас 6 . 2-р өгүүлбэр

Дээд боловсролын байгууллага хоёр дахь шатны магадлан итгэмжлэлд ороход сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хийлгэсэн байхыг заавал биелүүлэх урьдчилсан шаардлага болгоогүй. Харин ахиц дэвшлийн тайлан бичихэд "Сургалтын агуулга, хөтөлбөрийг үнэлэх, сургуулийн түвшинд магадлан итгэмжлэх талаар хийсэн ажил, БМИҮЗ-өөр ямар хичээлийн хөтөлбөр магадлан итгэмжлэгдсэн" талаар бичихийг зөвлөмж болгосон байдаг. Иймээс манай сургуульд БМИҮЗ-өөр хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хийлгээгүй боловч түүний урьдчилсан нөхцөл болох сургалтын хөтөлбөрийн чанарын үнэлгээний тогтолцоог бий болгох талаар хийсэн ажлаа ахиц дэвшлийн тайланд тодорхой бичсэн болно.

Тухайлбал, МУИС нь дээд боловсролын байгууллагуудаас хамгийн анх дотооддоо сургалтын хөтөлбөрт чанарын өөрийн үнэлгээ хийх ажлыг нэвтрүүлсэн төдийгүй үүнтэй холбоотой дүрэм/журмыг ТАСИС төслийн хүрээнд боловсруулж хэрэгжүүлсэн. Ийнхүү (давхардсан тоогоор):

- 2000-2001 онд 3 хөтөлбөр
- 2001-2002 онд 10 хөтөлбөр
- 2002-2003 онд 12 хөтөлбөр
- 2003-2004 онд 10 хөтөлбөр
- 2004-2005 онд 5 хөтөлбөрт өөрийн үнэлгээ хийж,

2004 онд хоёр дахь шатны магадлан итгэмжлэлд бэлтгэх үед нийт 20 сургалтын хөтөлбөрт дотооддоо чанарын өөрийн үнэлгээ хийсэн байсан.

Мөн 2000-2001 онд Нягтлан бодох бүртгэл, Менежментийн хоёр хөтөлбөрт олон улсын нэр хүнд бүхий эрдэмтэдийн бүрэлдэхүүнтэй шинжээчдээр

хөндлөнгийн үнэлгээ хийлгэсэн. Гадаадын шинжээчдээр хийлгэсэн "Хөндлөнгийн үнэлгээ" нь БМИҮЗ хүлээн зөвшөөрч шууд магадлан итгэмжилж болохуйц үйл ажиллагаа болсон гэж үзэх үндэстэй байсан юм.

Нөгөө талаар Сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх тухай журам хэрэгжиж эхлэх бодит хугацаа нь 2004-2005 оны хичээлийн жил байсан бөгөөд МУИС нь үүнээс өмнө буюу 2003-2004 оны хичээлийн жилээс хоёр дахь шатны магадлан итгэмжлэлийн тайлангаа бэлтгэж эхэлсэн тул цаг хугацааны хувьд БМИҮЗ-өөр сургалтын хөтөлбөр магадлан итгэмжлүүлэх боломжгүй байсан.

Тайлбар 2.3 -ыг
үзнэ үү.

Хуудас 9. 2-р өгүүлбэр:

Эрдэм шинжилгээний ажлын үр дүнг сургалтанд нэвтрүүлэх ажил хангалтгүй гэсэн дүгнэлт өрөөсгөл болжээ. Аливаа их сургууль нь сургалт, эрдэм шинжилгээ, нийгмийн үйлчилгээ гэсэн гурван үндсэн үүрэгтэй байдагтай холбоотойгоор багш нь сургалтын зэрэгцээ судалгаа шинжилгээний ажил хийх үүрэгтэй. Иймээс харьцангуй бие даасан бөгөөд биенээ нөхөн гүйцээж байдаг энэ хоёр үндсэн үүргийн талаар багшийн ажлын үнэлгээний журамд тодорхой зааж, үр дүнг жил бүр үнэлж, хөдөлмөрийн хөлстэй нь холбож байдаг. Их сургуулийн багш бүхэн судалгааны ажил хийдэг байх, зааж байгаа хичээлийн агуулгыг тухайн салбарт гарч байгаа судалгааны ажлын шинэлэг үр дүнгээр байнга баяжуулж байх нь МУИС-ийн багшийн ажилд тавьж байгаа нийтлэг шаардлагын нэг юм. Манай багш нарын 85 хувь нь гадны (оюутны төлбөрийн бус) санхүүжилттэй эрдэм шинжилгээний төсөл, сэдэвт ажилд оролцдог.

Багш нь оюутны курс, дипломын ажлыг удирдаж, эрдэм шинжилгээний хуралд илтгэл бэлтгүүлэн тавиулдаг, магистр, докторын судалгааны ажлын удирдагчаар ажилладаг, тэднийг эрдэм шинжилгээнийхээ төсөлт ажилд гүйцэтгэгчээр дагуулан ажиллуулдаг нь эрдэм шинжилгээний ажлын үр дүнг сургалтад нэвтрүүлж буйн жишээ. Тэрчлэн тэргүүлэх профессоруудын удирдан явуулдаг "мэргэжлийн судалгааны семинар"-ыг МУИС анхлан нэвтрүүлсэн нь сургалтын агуулгыг шинэчлэх, түвшинг дээшлүүлэх, сургалт-эрдэм шинжилгээний нэгдлийг хангах талаар гарч буй бодит үр дүн гэж үзэж болно.

Зөвхөн 2004 оны үзүүлэлтээр их сургууль дээр хэрэгжиж байгаа эрдэм шинжилгээний төсөл, сэдэвт ажилд оролцсон 78 магистрант дипломын ажлаа амжилттай хамгаалжээ. Жил бүр зохиогддог оюутны эрдэм шинжилгээний бага хуралд их сургуулийн хэмжээгээр 300 гаруй оюутан илтгэл хэлэлцүүлж байна.

Тайлбар 2.4 -ийг үзнэ үү.

Хуудас 10 . Дунд хэсгээс доош байгаа өгүүлбэрүүд:

2004-2005 онд явуулсан сургалтын анги, танхимийн аттестатчлын дүнгээс харахад:

- 1 оюутанд оногдох талбай нь стандартын шаардлагын 94%-тай, 1 суудалд оногдох талбай стандартын шаардлагын 80%-тай тэнцүү байна. Өөрөөр хэлбэл стандартын шаардлагаас 6% ба 20%-иар доогуур байна гэсэн үг.
- Ээлж ашиглалтын коэффициент МУИС-ийн хувьд дунджаар 1.1 байгаа нь стандартаас 25%-иар хэтэрсэн биш харин 30%-иар бага байна. Стандартаар зөвшөөрөгдсөн ээлж ашиглалтын коэффициент 1.6 байдаг.
- МУИС нь нийтдээ 900 орчим суудал бүхий номын сан болон оюутны бие даах төвүүдэд 340000 орчим ном сурах бичигтэй. Энэ үзүүлэлтээс харахад 1 оюутанд дунджаар 38 ном сурах бичиг / нормоор: 1 оюутанд 20 ном/ ноогдож, суудлын тооны хувьд стандарт шаардлагын 70%-ийг хангаж байгаа юм. Мөн түүнчлэн 400 гаруй CD, аудио/видео материал бүхий компьютерийн танхим нь оюутан багш нарт дэлхийн томоохон их сургуулиудын электрон мэдээллийн санг ашиглах бололцоог олгож байгаа. Мэргэжлийн ном, сэтгүүлээр номын фондоо баяжуулахад жил бүр 15-20 сая төгрөг зарцуулж байгаа нь шаардлагын хэмжээнд хүрэхгүй ч энэхүү компьютерийн кабинетээр онлайн хэлбэрээр ашиглах бүрэн бололжтой.
- Анги дүүргэлт МУИС-д дунджаар 32.5 оюутан байгаа нь нормоос 2.5 –аар буюу 8%-иар хэтэрсэн гэсэн үг. Ер нь МУИС - ийн бүрэлдэхүүний 12 сургууль/факультетээс 7 –д нь 30-аас бага оюутан, 5 –д нь 30-аас дээш оюутан нэг ангид оногдож байна. /МКС-27, МТС-34, ФЭС- 27, ХФ-14, БФ-34, ГГФ-32, НШУС-24, МХСС-27, ГХСС-26, ОУХС-66, ЭЗС-28, ХЗС-51 /

Тайлбар 2.5 -ыг үзнэ үү.

Хуудас 14. 2-р өгүүлбэр:

МУИС-ийн багшийн ажлын нэгдсэн үнэлгээг (аттестатчилал) 1999 оноос хойш 3 жилийн мөчлөгтэйгээр явуулж ирсээр одоо 2-р мөчлөгийн 3 дахь жилийн аттестатчилалыг 2005-2006 онд хийх гэж байна.

1-р мөчлөгт 1999-2000, 2000-2001, 2001-2002 (2002-2003 онд өмнөх жилүүдэд хамрагдаагүй багш нар) бүгд 384 багш орсон; Энэ хугацаанд жилд дунджаар 460 орчим багш ажиллаж байснаас 170 орчим хүн урт, богино хугацааны томилолтоор гадаадад явсныг харгалзан үзвэл аттестатчилалд орох ёстой бүх багш нар хамрагдаж чадсан.

2-р мөчлөгт 2003-2004, 2004-2005 онд 205 багш орсон байгаа бөгөөд 2005-2006 оны хичээлийн жилд 100 гаруй багш аттестатчилалд оруулахаар бэлтгэж байна. 2004 оны байдлаар үндсэн багшийн тоо 500 орчим байгаа бөгөөд гадаадад урт, богино хугацаагаар явсан хүмүүс, ажиллаж эхлээд аттестатчилагдах хугацаа нь болоогүй багш нарыг тооцвол хүндэтгэх шалтгаангүйгээр аттестатчилагдаагүй багш байхгүй.

Аттестатчилалын үр дүнг сургууль, факультетууд тухайн багшийг цаашид ямар албан тушаал дээр ажиллуулах, шагнал урамшуулал олгох, дэвшүүлэх зэрэгт харгалздаг нэгэн үзүүлэлт болгон ашигладаг.

Тайлбар 2.6 -г
үзнэ үү.

Хуудас 17 . 5-р өгүүлбэр

"Гэвч тус програм нь нягтлан бодох бүртгэлийн програмыг хэрглэх, худалдах зөвшөөрөл олгох тухай холбогдох журмын дагуу зөвшөөрөл авагдаагүй байна" гэсэн мэдээлэл ташаа болжээ.

- 1995 онд сангийн яамны дэргэдэх Мэргэжлийн зөвлөлөөс нягтлан бодох бүртгэлийн програмыг аж ахуй нэгж, байгууллагуудад хэрэглэх, худалдах зөвшөөрлийг анх Поверсофт системс компанийн "Powersoft 1.0" програм хангамжид олгосон.

MS DOS орчинд ажиллах хувилбарууд нь тогтмол шинэчлэгдэн

1994-1997 онд "Powersoft Accouting 1.0"

1997-2000 онд "Powersoft Accouting 2.0"

2000-2003 онд "Powersoft Accouting 3.0-4.8"

2003 оноос "Power soft Systems" /Powersoft Accouting SQL/ болж ашиглагдаж байна.

/Програмыг хэрэглэх худалдах зөвшөөрлүүдийг хавсаргав./

- 2002 оны 12 дугаар сард тус сургуулийн нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, програм хангамжийн системийг Санхүү, Эдийн засгийн яамнаас шалгаж, зөвшөөрсөн батламж бичиг олгосон.
- Хандив тусламжийн орлогыг буруу ангилж бүртгэсэн зөрчлийг илрүүлээгүй, таслан зогсоогоогүй гэдэг нь анхны баримтаар зөв илэрхийлэгдсэн бөгөөд дотоод хяналтаар илрээгүй болно.

Тайлбар 2.7 -г
үзнэ үү.

Хуудас 19 . 4-р өгүүлбэр

Дүгнэлтэнд МУИС-иас үйлдвэр, аж ахуйн газартай гэрээгээр хийж байгаа эрдэм шинжилгээний ажлын хэмжээ бага байгаа гэсэн нь үнэний хувьтай боловч Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулдаг олон улсын болон аль нэг орны төсөл, хамтын ажиллагааны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа төсөл багагүй байгааг тэмдэглэх нь зүйтэй. Яамд өөрийн салбарын судалгааны тулгамдсан асуудлыг захиалгаар, улсын төсвөөс санхүүжүүлэн гүйцэтгүүлэх сонирхол давамгайлж байгаа өнөөгийн нөхцөлд өөрөө санхүүжилт гаргаж эрдэм шинжилгээний байгууллагатай гэрээ байгуулах сонирхолтой үйлдвэр, аж ахуйн нэгж хараахан гарахгүй байна. Үйлдвэр, аж ахуйн газар гаднаас бэлэн бүтээгдэхүүн, бэлэн технологи импортлох биш, харин өөрийн бүтээгдэхүүн, технологитой болох үйл ажиллагааг дэмжсэн эрх зүй, эдийн засгийн механизм, хөшүүргийг засгийн газраас бодлогоор зохицуулан боловсруулан гаргаж байж сая захиалагч, гүйцэтгэгчдийн хооронд ажил хэргийн амьд холбоо бий болно.

Тайлбар 2.8 -ыг
үзнэ үү.

Их сургуульд зориулж гаргах дүгнэлтэнд оруулах санал:

- Их сургуулиар байгаль, нийгэм, хүмүүнлэгийн олон нарийн мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэх улсын хэмжээний эрэлт хэрэгцээ, их сургуульд бүрэлдэн тогтсон оюуны чадавхийг улс орны хөгжлийн ирээдүйд бүтээлчээр ашиглах, улмаар хөгжүүлэх, суралцагчдын сурч, боловсрох орчин нөхцлийг сайжруулах замаар бүс нутаг, олон улсын хэмжээнд өрсөлдөх чадвартай сайн мэргэжилтэн бэлтгэхэд нь дэмжлэг үзүүлэх төрийн бодлогын үндэслэлийг боловсруулж ойрын үед их хурлын нийгмийн бодлогын байнгын хороонд оруулж хэлэлцүүлэх,
- Их сургуулийн салбар сургууль, факультет, тэнхим, хүрээлэн, төв, эрдмийн бусад хамтлаг, эрдэмтэд үйлдвэр, аж ахуйн газартай гэрээ байгуулж орлогоо нэмэгдүүлэх үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн эрх зүйн орчин, эдийн засгийн хөшүүрэг механизмыг улам боловсронгуй болгох талаар оновчтой арга хэмжээ авч хэрэгжүүлэх,
- Их сургуулийн ахисан төвшний сургалтыг чанаржуулах, сургалт эрдэм шинжилгээний ажлын уялдаа холбоог бэхжүүлэх, сургалтыг эрдэмжүүлэхэд их сургуулиас санаачлан хэрэгжүүлж байгаа мэргэжлийн судалгааны семинар ихээхэн үр дүнтэй ажил болохыг тэмдэглэхийн ялдамд энэ ажлыг улам чанаржуулан тогтмолжуулах, оролцогчдын хамрах хүрээг өргөжүүлэх, үр дүнг нэмэгдүүлэх талаар байнга анхаарч ажиллах.

СУИС-ийн санал



СОЁЛ УРЛАГИЙН ИХ СУРГУУЛЬ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 25, Утас 328845

2005 оны ...9... -р сарын 29. № 1302

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Улсын Их Хурлын Нийгмийн Бодлогын байнгын Хорооны хүсэлтээр танай байгууллагаас МУИС, СУИС-ийн сургалт, эрдэм шинжилгээ, удирдлага, санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитын "Шаардлага бүрэн хангаагүй сургуулиуд магадлан итгэмжлэгдэж иржээ" тайлантай танилцлаа.

Тайланд тус сургуулийн ололт амжилт, ахиц дэвшлийн холбогдолтой зарим зүйлийг ерөнхийлөн дурдсанд талархаж байна. Түүнчлэн цаашдын үйл ажиллагааны анхаарлын төвд байлгаж дотоод нөөц, бололцоог ашиглан сайжруулах шаардлагатай асуудлыг бид бүрэн дүүрэн хүлээн авч байна.

Гэвч дор дурдсан асуудлын талаар тайлбар хийхээс аргагүй боллоо.

Тайлбар 3.1 -ийг
үзнэ үү.

1.Тайлангийн "Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийн боловсруулалт" хэсэгт "Харин сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл бүрээр суралцагчдын эзэмшвэл зохих онол, дадлагын хичээлийн агуулга, цар хэмжээг тодорхойлдог хичээлийн хөтөлбөрийг боловсруулахад тавигдах шаардлагыг хангуулах талаар удирдлагаас тодорхой хяналт, үнэлгээ хийж байгаагүй ажээ".

Тайлбар. Эдгээр баримт бичгийг боловсруулах, хэлэлцэж батлах, мөрдөхөд БСШУЯ-наас гаргасан журмыг хатуу баримталдаг бөгөөд улирал, жил бүр биелэлтийг суралцагч, багш бүрээр гаргаж дүгнэдэг, сургалтын явцад хяналтын ажил авах, сэдвийн дүн гаргах, реферат, эссе, илтгэл, өгүүлэл бичүүлэх, онол практикийн хуралд оролцуулах, мэргэжлийн ур чадварын академи хяналт авах, тайлан тоглолт хийлгэх, сургалтын явц, үр дүнг тэнхим, факультет, захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэх зэргээр бүх шатанд удирдлагын хяналт тавьж ажилладаг. Өрөөр хэлбэл, сургалт, эрдэм шинжилгээний ажлын үндсэн нэгж, хэсэг болох тэнхим, факультет, сургалтын алба, эрдмийн зөвлөл шат шатандаа сургалтын үндсэн баримт бичгийн боловсруулалт, биелэлтийг хянаж, дүгнэх хүртэл үйл ажиллагаа явуулж зохион байгуулж ирсэн тогтолцоотой.

Тайлбар 3.2 -ыг
үзнэ үү.

Мөн энэ хэсэгт "Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн чанарт үнэлгээ өгөх хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааг Боловсролын тухай хууль, Боловсролын магадлан итгэмжлэх байгууллагын дүрэмд тодорхой зааж өгсөн байтал СУИС-д энэ ажил огт хэрэгжээгүй байна" гэжээ.

Дээд боловсролын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хийлгэх асуудлыг ойлгуулах, бэлтгэлийг хангуулах талаар Дээд боловсролын магадлан итгэмжлэх байгууллага сүүлийн 4 жилийн турш ажиллаж байгаа. Энэ нь байгууллагын магадлан итгэмжлэлээс эрс өөр бөгөөд тухайн мэргэжлээр бакалаврын боловсролтой мэргэжилтэн бэлтгэхэд хамаарах бүх асуудлыг тусгай үзүүлэлтүүдээр өөрийн орны болон гадаадын ижил сургуулиудад яг тэр мэргэж-

лээр бэлтгэж байгаа түвшинтэй харьцуулан авч үздэг. Тус сургууль 2002 оноос төгөлдөр хуур, утсан хөгжмийн мэргэжлээр бакалаврын боловсролтой мэргэжилтэн бэлтгэж байгаа хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хийлгэх бэлтгэлийг хангаад тэр тухайгаа холбогдох байгууллагад мэдэгдээд байна.

Байгууллагын болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг тухайн байгууллагын хүсэлт, зардлаар хийлгэдэг журамтай. Бид магадлан итгэмжлэлийг ажил сайжруулах чухал хөшүүрэг, зэвсэг гэж үзэж анхны болон хоёр дахь магадлан итгэмжлэлийг эхний хэдхэн төрийн өмчийн сургуулийн хамт хийлгэсэн. Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг МУИС, ХААИС, ШУТИС, СУИС л дөнгөж эхлүүлээд байгаа. Уг магадлалыг бүх мэргэжлээр хийлгэдэг учир их хугацаа, хүч, хөрөнгө гардаг.

Үүнтэй уялдуулан та бүхэн тайлангийнхаа нэрийг эргэж харах нь зүйтэй гэсэн санал тавьж байна.

Тайлбар 3.3 -ыг үзнэ үү.

2. **"Онол, дадлагын хичээлийн зохион байгуулалт, хэрэгжилт"** хэсэгт "СУИС-д суралцагч, багш нараас аудитын багийн авсан санал асуулгаар мэргэжлийн /?/ болон мэргэшүүлэх хичээлийн /?/ хангалттай бус, компьютерийн кабинет, техник хэрэгслийн хангамж муу, аудио, видео хэрэгсэл, цахилгаан хөгжмийн лаборатори, электрон мэдээллийн номын фонд дутагдалтай зэрэг зөрчил дутагдал дурдагджээ" гэжээ.

Тайлбар. Дээд боловсролын тухай хуулийн 3-р зүйлийн 2-рт "Дээд боловсролын агуулга нь ерөнхий суурь, мэргэжлийн суурь болон мэргэших хэсгээс бүрдэх ..." гэж заасан байдаг тул тайлангийн 7-р талын дээрээсээ 2 дахь мөрөнд байгаа "...мэргэжлийн болон мэргэшүүлэх" гэдэг ойлгомжгүй байна. Мөн энэ мөр дэх "... хичээлийн" гэдэг үгийн дараа үг орхисон байна. Өөрөөр хэлбэл, юу нь "... хангалттай бус" болох нь тодорхойгүй байна. Үүнийг тодруулж урьдчилан мэдэгдэхийг хүсье. Энд дурдсан санхүү, байр танхимын холбогдолтой дутагдлыг ойрын хугацаанд дэс дараатай засах болно.

Тайлбар 3.4 -ийг үзнэ үү.

3. **"Хичээлийн хөтөлбөр, агуулгыг боловсруулах, баяжуулахад эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр нөлөө"** хэсэгт ... эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр нөлөөг хичээлийн агуулга, хөтөлбөрийн баяжилтад хэрхэн ашиглаж байгааг удирдлагаас хянах, үнэлэх тогтолцоо бүрдээгүй байна" гэснийг өөрчилж бодит үнэлгээ өгөх нь зүйтэй.

Учир нь анхан шатны (1999) болон хоёр дахь (2004) шатны магадлан итгэмжлэл хийлгэх, сургалтын төлөвлөгөө, агуулгын стандартыг 4 удаа өөрчлөн шинэчлэх бүрт 200 гаруй хичээлийн агуулгыг дэлхийн олон улсын болон өөрийн орны шинжлэх ухаан, технологи, техникийн дэвшлийн ололт амжилтаар баяжуулж ирсэн юм. Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг эрдэмийн зэрэгтэй, ажил, мэргэжлийн өргөн гүнзгий мэдлэг, өндөр ур чадвартай багш, баг боловсруулж тэнхим, эрдмийн зөвлөлийн хурлаар шүүн хэлэлцэж зөвшөөрдөг журамтай. Нөгөөтэйгүүр сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, хичээлийн агуулгын стандартыг боловсруулах журмыг БСШУЯ гаргасан.

Тус сургуулийн сургалтын үндсэн баримт бичгийн боловсруулалт, суралцагчдын эзэмшсэн мэдлэг, чадварын түвшинг дэлхийн олон улс хүлээн зөвшөөрч оюутан, магистрант, докторант элсүүлэн суралцуулах, солилцох зэргээр ажиллаж байхад дээрхи дүгнэлт үндэслэлгүй юм.

Тайлбар 3.5 -ыг үзнэ үү.

4. **"Дээд боловсролын байгууллагад тавигдах үндсэн шаардлагын биелэлт"** хэсэгт ... эдгээр сургуулиуд Монгол улсын гэгээрлийн сайдын 1999 оны 61-р тушаалаар батлагдсан "Мэргэжлийн сургуулийн элсэлтийн үлгэрчилсэн

журам"-аас гадуур, батлагдсан хяналтын тооноос илүү оюутан элсүүлсэн бөгөөд Дээд боловсролын байгууллагад тавигдах нийтлэг шаардлага дараах байдлаар хангагдаагүй байхад 2004 оны 7-р сард 2 дахь шатны магадлан итгэмжлэлийг 10 жилийн хугацаатай авсан байна" (Тайлангийн 10 дахь тал)

СУИС Дээд боловсролын байгууллагад тавигдах үндсэн шаардлагын 25 үзүүлэлтээс 14 буюу 56 %-ийг хангаж, хичээлийн болон оюутны дотуур байр, талбайтай холбоотой шаардлагыг хангаагүй байна" гээд нэг оюутанд ноогдох талбай, нэг суудалд ноогдох талбай стандартын шаардлаас 20-45 %-иар доогуур байгаа, ээлж ашиглалтын коэффициент 38 %-иас хэтэрсэн, нэг багшид ноогдох талбайн хэмжээ шаардлагын хэмжээнд хүрээгүй, оюутны байрны 1 оюутанд ноогдох талбайн хэмжээ шаардлагын түвшинд хүрэхгүй, хэт олон оюутан агааржуулалтын нөхцөл, эрүүл ахуйн шаардлага хангагдаагүй анги танхимд хичээллэдэг гэж үзсэн нь учир дутагдалтай байна гэжээ.

БСШУЯ-ны хяналт шинжилгээний газар жил бүр байр талбайн мэдээ тайлан авч зарим жил газар дээр нь танилцаж байв. Нэг өрөө, тасалгааны даац хэтрүүлэн сандал, ширээ тавьж хичээл зааж байгаа тохиолдол гарч байсангүй. Багш, оюутанд ноогдох талбай нормын дагуу байгаа болно. Дээд боловсролын байгууллагад тавигдах үндсэн шаардлагын 14 буюу 56 %-ийг хангаж байна гэдэг дүгнэлтийг дэндүү өнгөц байдлаар өгчээ. Үүнийг бодит үнэнд ойртуулах нь зүйтэй.

Тайлбар 3.6 -г
үзнэ үү.

Энэ хэсэгт "Тус сургуулийн хичээлийн болон оюутны байрны хүчин чадал стандартын шаардлагыг хангахгүй байсаар атал БСШУ-ны яам жил бүрийн элсэлтийн тоог 100-115-аар нэмэгдүүлж ирсэн төдийгүй сургууль өөрөө элсэлтийн шалгалтын журам, элсэлтийн хяналтын тоог зерчиж хандив гаргуулах нөхцлөөр оюутан нэмэж элсүүлж байжээ" гэж дүгнэлт хийжээ.

Тайлбар.

- Тус сургууль хичээлийн байрны хүчин чадал, орчин нөхцөл, тухайн жилд төгсөгчид, дэвшин суралцах оюутны тоог үндэслэн жил бүрийн элсэлтийн тооны тухай саналаа боловсруулж БСШУ-ны яаманд өгдөг. Яам олон төрлийн мэдээ тайлан, судалгааг үндэслэн жил бүрийн элсэлтийн хяналтын тоо, Засгийн газрын хөнгөлөлт үзүүлэх оюутны тоог баталдаг журамтай. Үүнийг энд тайлбарлах нь илүүц боловч дурдахаас өөр аргагүй. Тус сургууль 2001-2004 онд буюу сүүлийн 4 жилд тусгай зөвшөөрлийн дагуу сургалт явуулж буй ангиудад 1760 оюутан (жилд 440) шинээр элсүүлэн сургах эрхтэй байсан боловч хүчин чадалдаа тохируулан 956 оюутан элсүүлсэн. Дурдсан 4 жилд БСШУЯ 1100 оюутан элсүүлэх хяналтын тоо баталж өгсөн. Бид жил бүрийн хяналтын тооноос хэтрүүлэн оюутан элсүүлж байсангүй. (Элсэлтийн судалгааг хавсаргав).

- Өнгөрсөн жилүүдэд хандив авч оюутан элсүүлж байсан тохиолдол байгаагүй.

Тэгээд ч тус сургууль хүсэл, сонирхолтой иргэн бүрийг элсүүлдэггүй. Урлагийн авьяас, чадвар нь тодорхой түвшинд хүртэл хөгжсөн, зохих шатны боловсролтой хүмүүсийг шилж, нарийн сонголтоор элсүүлдэг. Манай оюутнууд эхний курсүүдээсээ эхлэн улс, олон улсын мэргэжлийн уралдаан, тэмцээнд орж тэргүүн, дэд, шагналт байрууд эзэлдэг. Манай оюутнууд, төгсөгчдөд Монголын төдийгүй, дэлхийн үзэгч, судлаачид үнэлэлт өгч байдаг. Тэд сургуулиа, мэргэжлээ сайн сурталчилдаг. Ийм учраас БНХАУ, ОХУ, Япон зэрэг орноос элсэн суралцагчдын тоо жил бүр нэмэгдэж байна.

Тайлбар 3.7 -г
үзнэ үү.

5. “Дотоод хяналтын тогтолцоо, түүний үр нөлөө” хэсэгт ... СУИС сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжилт, агуулгын баяжилт, түүнд тавигдах нийтлэг шаардлагыг хангуулах талаар удирдлагын хяналтын тогтолцоо мөн бүрдээгүй байна” гэжээ.

Тайлбар. Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, агуулгын стандартад хэдийд ямар өөрчлөлт оруулсан тухай нарийн судалгаа, тайланг удирдлагын бүх шатанд гаргадаг. Сургалтын үндсэн баримт бичгүүдийг боловсронгуй болгох, нэмэлт өөрчлөлт оруулж сайжруулах ажлыг тэнхим, сургалтын алба удирдан зохион байгуулж хяналт тавьж, редакци хийгээд сургуулийн эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж зөвшөөрсний үндсэн дээр захирал баталж мөрддөг. Энэ бол нарийн журам, тогтолцоотой уламжлалт гол ажил юм. Энэ талаар дээр (3-р тайлбар) дурдсан.

Сургалтын үндсэн баримт бичгүүдийг боловсруулахад баримталдаг зарчим, журмыг дурдах нь илүүц гэж үзлээ.

Та бүхнийг бидний ажилд тус болох бодитой дүгнэлт гаргана гэдэгт итгэж байна.



ТӨРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ

Проф. Г.АЛТАНГЭРЭЛ

ҮАГ-ын тайлбар

1. БСШУЯ-ны саналд өгөх тайлбар

Тайлбар 1.1

Дээд боловсролын тухай хуульд “мэргэжилтний хэрэгцээ, захиалга, сургуулийн хүчин чадлыг харгалзан элсэгчдийн тоог боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно...” гэж заасны дагуу БСШУЯ жил бүр их, дээд сургуулиудад элсэлтийн хяналтын тоог баталж өгдөг. 2003 онд БСШУ-ны Сайдын 178 дугаар тушаалаар МУИС-д 2000, СУИС-д 210, 2004 онд БСШУ-ны Сайдын 180 дүгээр тушаалаар МУИС-д 2235, СУИС-д 290, 2005 онд БСШУ-ны Сайдын 179 дүгээр тушаалаар МУИС-д 2440, СУИС-д 325 гэж элсэлтийн хяналтын тоог жил тутам нэмэгдүүлэн баталж ирсэн байна.

Тайлбар 1.2

МУИС хичээлийн шинэ байрны барилгын ажлыг санхүүжүүлэхэд арилжааны банкнаас зээл авсан нь ТБУСТухай хуулийн 14.1.1 заалттай зөрчилдөж байна.

2. МУИС -ийн саналд өгөх тайлбар

Тайлбар 2.1

Аудитын тайлангийн төсөлд хичээлийн хөтөлбөр боловсруулах ажлын хэрэгжилтийн талаар биш, харин хичээлийн хөтөлбөрт тавигдах шаардлагууд, түүний дотор “шинжлэх ухаан, технологийн сүүлийн үеийн ололт амжилтыг тусгаж байх” шаардлагыг хангуулах, удирдлагаас хяналт, үнэлгээ хийх талаар дурдсан билээ.

Тайлбар 2.2

Ирүүлсэн тайлбарын дагуу сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх талаар МУИС-ийн санаачлан хийж байгаа ажлыг аудитын тайланд нэмж тусгалаа. Мөн хэрэгжилтийг хангуулахад цаг хугацааны хувьд боломжгүй талаархи тайлбарыг хүлээн зөвшөөрч, аудитын дүн, дүгнэлтэд залруулга хийсэн.

Тайлбар 2.3

Аудитын тайлангийн төсөлд “Эрдэм шинжилгээний ажлын үр дүнг сургалтад нэвтрүүлэх ажил хангалтгүй” гэдэг дүн, дүгнэлт гараагүй. Харин эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг сургалтад хэрхэн нэвтрүүлж байгааг “хянах, үнэлэх тогтолцоо бүрдээгүй” гэсэн бөгөөд аудитын дүнг “хянаж, үнэлж байх шаардлагатай байна” гэж өөрчлөн найруулсан болно.

Тайлбар 2.4

Нийтлэг шаардлагын биелэлтийг тооцох үзүүлэлтүүдийг сургуулиас гаргаж өгсөн тоо, баримтад үндэслэн тооцсон. Харин ээлж ашиглалтын коэффициентын талаархи тайлбарыг зөвшөөрч байгаа бөгөөд “25%-иар хэтэрсэн” гэснийг “30%-иар бага байгаа нь анги танхим дахь суудлын тоог хэтрүүлсэнтэй холбоотой байна” гэж өөрчлөн найруулсан болно. Номын сангийн тухайд номын фондын баяжилт, мэргэжил тус бүрээр 2-3 гадаад, дотоод тогтмол хэвлэл захиалж байх шаардлагыг биелүүлээгүй байдлыг дурьдсан болно. Анги дүүргэлтийг бид бүрэлдэхүүн сургууль, нэгж бүр дээр биш, МУИС-ийн хэмжээнд нэгдсэн байдлаар тооцоолсон бөгөөд энд зарчмын ялгаа байхгүй гэж үзсэн.

Тайлбар 2.5

Багш нарын аттестатчиллын талаархи тайлбарыг хүлээн зөвшөөрч, аудитын дүнг залруулсан.

Тайлбар 2.6

МУИС-д ашиглагдаж байгаа нягтлан бодох бүртгэлийн программын танилцуулгыг санхүүгийн албанаас аудитын явцад гаргаж өгөхдөө “Windows-SQL” гэж нэрлэж байсан билээ. Гэтэл ирүүлсэн тайлбарт программын нэрийг “Powersoft Systems” гэснийг нягтлаад аудитын дүнг залруулсан.

Тайлбар 2.7

Мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн орчинд аж ахуйн нэгж, байгууллагууд их, дээд сургууль болон эрдэм шинжилгээний төв, хүрээлэнтэй шинжлэх ухаан, технологи, судалгааны чиглэлээр хамтарч ажиллахад бүрэн боломжтой гэж үзэж байна. Үүний жишээ нь 2002-2004 онд МУИС-иас “Эрдэнэт” үйлдвэрт хийсэн технологийн шинэчлэлийн төсөл юм.

Тайлбар 2.8

Ирүүлсэн саналыг нягтлан үзээд аудитын зөвлөмжид зохих нэмэлт оруулсан болно.

3. СУИС -ийн саналд өгөх тайлбар

Тайлбар 3.1

Сургалтын хөтөлбөрийн боловсруулалт, баяжуулалттай холбоотой аудитын дүн, дүгнэлтэд өгсөн тайлбарыг хүлээн зөвшөөрч, зохих залруулга хийсэн.

Тайлбар 3.2

Сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлээр тус сургуулийн хийж байгаа бэлтгэл ажлыг аудитын дүнд тусгав.

Тайлбар 3.3

“Мэргэжлийн суурь хичээл” гэдэг нэр томъёог дутуу бичсэн, мөн “хичээлийн” гэдэг үгийн дараа “цаг” гэдэг үгийг орхигдуулсныг залруулан бичлээ.

Тайлбар 3.4

Тайлбарыг үндэслэн зохих залруулга хийсэн.

Тайлбар 3.5

СУИС-иас гаргаж өгсөн тоо, мэдээ, баримтад үндэслэн шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтийг гаргасан болно.

Тайлбар 3.6

Тус сургуулийн байр талбайн хүчин чадал хэвээр байхад БСШУЯ-наас элсэлтийн хяналтын тоог 2003 онд 210, 2004 онд 290, 2005 онд 310 гэж жил бүр нэмэгдүүлэн баталж ирсэн байна. Харин “дунджаар 100-115-аар” гэдгийг “дунджаар 20-80-аар” гэж өөрчилж, хандив гаргуулах нөхцөлөөр хяналтын тооноос хэтрүүлэн оюутан нэмж элсүүлсэн гэснийг залрууллаа.

Тайлбар 3.7

Тайлбарыг хүлээн авч, зохих ёсоор залруулсан болно.

Зөвлөмж

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд П.ЦАГААНД:

- 1.1. Их, дээд сургуулиудыг орчин үеийн шаардлага, олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны үр нөлөөг дээшлүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг шинэчлэн боловсруулж, зохих журмын дагуу батлуулан мөрдөх;
- 1.2. Их, дээд сургуулиудын сургалт, эрдэм шинжилгээ, удирдлага, санхүүгийн үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох, эдийн засаг, санхүүгийн хөшүүрэг, механизмыг бүрдүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээний санал боловсруулж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх;
- 1.3. Монгол Улсын дээд боловсролын стандартыг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг хангуулах ажлыг эрчимжүүлэх;
- 1.4. Дээд боловсролын сургалтын байгууллага, хөтөлбөрийн магадлан итгэмжлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээ авах;
- 1.5. БМИҮЗ-ийн үйл ажиллагаанд чанарын хяналт тавьж, шаардлагатай гэж үзвэл магадлан итгэмжилсэн үндэслэлийг эргэж харан, холбогдох арга хэмжээ авч ажиллах.

2. МУИС, СУИС-ийн удирдлагад:

- 2.1. Дээд боловсролын байгууллагад тавигдах нийтлэг шаардлагыг бүрэн хангахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- 2.2. Хичээлийн хөтөлбөрийг боловсруулах, баяжуулахад тавигдах шаардлагуудыг бүрэн хангуулах, түүний хэрэгжилтийг хянах, үнэлэх дотоод хяналтын тогтолцоог сайжруулах;
- 2.3. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг нэмэгдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- 2.4. Оюутны элсэлттэй холбогдох журам, заавар, баталсан тоо хэмжээг мөрдөж ажиллах.

Гүйцэтгэлийн аудитын тайлантай холбоотой нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 263533 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

О. МЭНДБАЯР

Дээд боловсролын байгууллагад тавигдах нийтлэг шаардлагын биелэлт

Шалгуур үзүүлэлт	Стандарт шаардлага	Бодит хэрэгжилт	
		МУИС	СУИС
а. Хичээлийн байр талбайн стандарт хэмжээ:			
- 1 оюутанд ногдох талбай	2.0	1.2	1.6
- Лабораторийн 1 суудалд ногдох талбай	2.5	2.0	1.4
- Бүх төрлийн кабинет 1 суудалд ногдох талбай	2.2	2.0	1.2
- Ээлжийн ашиглалтын коэффициент	1.6	1.2	1.0
б. Хичээлийн байрны талаар хангасан байх шаардлагууд:			
- Лабораторийн өрөө	1	118	1
- Компьютерийн өрөө	1	19	2
- Номын фондын өрөө	1	4	1
- Уншлагын өрөө	1	5	2
- Захирлын өрөө	1	12	1
- Багш нарын өрөө	1	111	5
- Захиргаа аж ахуйн өрөө	1	25	8
- 1 багшид 4 кв.м-ээс доошгүй талбай ногдохоор тооцох	4.0	5.0	1.1
- Өөрийн оюутны байртай эсэх	байх ёстой	4 байртай	байхгүй
- Оюутны байранд амьдрах 1 оюутанд 4 кв.м-ээс доошгүй талбай ногдох	4.0	4.4	3.0
- Сургалтын зориулалттай барилга, байгууламжтай эсэх, барилгын норм ба дүрэм / БНБД-И166-88/ -д заасан байр, талбайн хэмжээ, эрүүл ахуйн нормативыг хангасан байх		зориулалтын 6 хичээлийн байртай	зориулалтын бус байртай
в. Номын сан:			
- 1 оюутанд ногдох ном сурах бичгийн тоо 20-оос дээш, эсвэл нэг анги бүлэгт 3000-аас дээш байх	1 оюутанд 20	1 оюутанд 37 ногдож байна	1 оюутанд 23, анги бүлэгт 270
- Мэргэжлийн ном сурах бичиг нь 3 оюутан тутамд 1-ээс дээш байх	3 оюутанд 1-ээс дээш	нийт 228382 ном сурах бичигтэй	нийт 3 оюутан тутам 11 ширхэг
- Сургуулийн бүх оюутны 15-аас доошгүй хувьд хүрэлцэх суудал бүхий номын сантай байх	15% хүрэлцэх	10% буюу 924 суудалтай	7.5% буюу 70 суудалтай
- Жил тутам номын сангийн фондыг 5-аас доошгүй хувиар, шинэ номоор баяжуулж байх	5%-иас доошгүй	1.5% буюу 3000-5000 ширх.	2.7% буюу 500-600 ширх.
- Мэргэжил тус бүрээр 3-аас доошгүй гадаад дотоодын тогтмол хэвлэл захиалах	мэргэжил тус бүрээр 3 ширхэг	нийт 40 буюу мэргэжилд 0.5 ширхэг	1 нийт 20 буюу 1 мэргэжилд 0.5 ширхэг
г. Багшийн тоо			
- Нийт багш нарын 60 хувиас доошгүй нь орон тооны багш байх	60%-иас доошгүй	95% нь орон тооны	100% орон тооны
- Үндсэн багш нарын 15 түүнээс дээш хувь нь эрдмийн цол зэрэгтэй байх	15%-иас доошгүй	46% докторын зэрэгтэй	23% эрдмийн цол, зэрэгтэй
- Компьютерийн дадлагын хичээл болон лингафон, лабораторийн 1 суудалд 2-оос дээшгүй оюутан байхаар сургалтыг зохион байгуулах	2-оос дээшгүй	2 ногдохоор зохион байгуулдаг	1.5 - 2 оюутан ногдож байгаа
- Гадаад хэл, компьютер, мэргэшүүлэх зарим бага бүлгээр хичээллэх оюутны тоо 15-аас ихгүй байх	15-аас ихгүй	18-27 оюутан	ихэвчлэн 1-2 оюутан
- Анги дүүргэлт 30 оюутнаас ихгүй байх	30-аас ихгүй	дунджаар 40	20-оос ихгүй
Нэгдсэн дүн			
Шаардлага хангасан		16	15
Шаардлага хангаагүй		9	10
Биелэлтийн хувь		64%	60%